**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ 2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

**НИЙСЛЭЛИЙН СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗАР 2022 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭС**

2022 оны 12 дугаар сарын 06-ны өдөр

| № | ЗДҮАХ-т тусгагдсан зорилт | Дугаар | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Үндсэн хэрэгжүүлэх байгууллага | Эх үүсвэр | Нийт хөрөнгийн хэмжээ /сая төгрөг/ | Суурь түвшин (2021 он) | Зорилтот жил 2022 он | | | Хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Төсөв /сая.төг/ | Төсвийн гүйцэтгэл /сая.төг/ | | |
| НЭГ. "КОВИД-19" ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГО | | | | | | | | | | | | | |
| 1.1. "Ковид-19" цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээ хэрэгжүүлэх, Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, нутгийн захиргааны байгууллагуудын салбар хоорондын харилцан ажиллагааг зохион байгуулах, гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангаж, эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлогыг хэрэгжүүлнэ. | | | | | | | | | | | | | |
| | 2.6.1 Үндэсний бахархал, монгол өв соёлыг өвлүүлж, олон улсын стандарт шаардлагад нийцсэн соёл, урлагийн байгууллагын шинэ барилга байгууламжуудын гадна тохижилт, гарын асуудлыг шийдвэрлэнэ. | 1. | 2.6.1.1.Үндэсний номын сангийн хуучин барилга, Дуурь бүжгийн Эрдмийн театр, Драмын Эрдмийн театрын барилгуудыг сэргээн засварлана. | 2021-2024 | СЯ, НЗДТГ НСУГ | Улсын төсөв | 28.370.0 | - | - | - | - | Соёлын яамнаас нийслэлийн нутаг дэвсгэр дэх дүүргийн хамгаалалтын зэрэглэлтэй дурсгалуудыг сэргээн засварлахаар тендер зарласан бөгөөд Улсын дуурь бүжгийн эрдмийн театрын барилгын их засварын ажлыг Захиалагч "Соёлын яам", зураг төслийг "Инсдо" ХХК гаргаж, уг тендерт "Марвелл хаус констракшн" ХХК шалгарч улсын төсвийн хөрөнгөөр /1.9 тэрбум/ дуурь бүжгийн эрдмийн театрын засварын ажлыг 2022.04.15-2022.12.01-ний хооронд дээврийн болон гадна фасадны ажлыг 85 хувьтай хийж гүйцэтгэсэн. Дотор дулаалгын ажил 4 дүгээр сард хийгдэхээр хойшлогдсон.<br>Монгол Улсын Үндэсний Номын сангийн хуучин барилгыг хүчитгэж, сэргээн засварлах ажлын зураг төслийн ажлыг "Алтан дуулга хаус" ХХК хийж гүйцэтгэж Соёлын яаманд хүргүүлсэн. 2023 онд 80-90%-аас дээш гүйцэтгэлтэй барилга байгууламжийн ажлыг | 85% |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | дуусгаж шинэ арга хэмжээний төслийг санхүүжүүлэхгүй учир 2023 оны яамны төсөвт тусгагдаагүй хойшлогдоод байна. /Соёлын яамны харьяа яамны төсвөөр хийгдэх ажил тул НЗД-н төлөвлөгөөнөөс хасуулах саналтай/ | |
| | 2. | 2.6.1.2.Үндэсний урлагийн их театр, Үндэсний номын сан, Хүүхдийн номын сан, Хүүхэлдэйн театр, Хүүхдийн соёлын өв. хөгжлийн төв, Хүүхэд залуучуудын театрын барилгыг шинээр барих газрын асуудлыг шийдвэрлэнэ. | 2021-2024 | СЯ, НЗДТГ НСУГ | Улсын төсөв | 32.000.0 | - | - | - | - | ҮНДЭСНИЙ УРЛАГИЙН ИХ ТЕАТР Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 29/33 дугаар тогтоолоор батлагдсан Нийслэлийн 2020 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний 4.2.14 дэх заалтын дагуу улсын төсвийн хөрөнгөөр Сүхбаатар дүүргийн 9, 11 дүгээр хороо, 10 га газарт Үндэсний урлагийн их театр баригдахаар тусгагдсан. Нийслэлийн Засаг даргын Газар эзэмших эрх олгох тухай" 2020 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн А/635 дугаар захирамжаар 5.5 га газрыг Үндэсний урлагийн их театрт эзэмшүүлсэн<br>ХҮҮХДИЙН НОМЫН САН, ХҮҮХЭЛДЭЙН ТЕАТР Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Хүүхдийн номын сан, Хүүхэлдэйн театр барих газрын батламжийг 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдөр Монголын үндэсний олон нийтийн телевизээр зохион байгуулсан хандивын аяны үеэр Соёлын сайдад гардуулан өгсөн. Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/23 дугаар захирамжаар Чингэлтэй дүүргийн 5-р хорооны нутаг дэвсгэрт 1,09 га газрыг Нийслэлийн Засаг даргын захирамжаар СБД-ийн 7-р хорооны нутаг дэвсгэрт 0.3 га газар олгосон. Төрийн худалдан авах ажиллагааны газраас улсын төсвийн санхүүжилтээр "Хүүхдийн номын сан, хүүхэлдэйн театрын цогцолбор барилгын зураг төсөв | 80 |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | шалгаруулах тендерийг 2022 оны 07 дугаар сарын 01-нд зарласан бөгөөд /1.304.830.000 төгрөг/ Засгийн газрын 2021 оны 6 дугаар сарын 1-ний өдрийн хуралдаанаар нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн тавдугаар хороонд барьж буй дүүргийн Соёлын ордны барилгыг улсын Хүүхэд, залуучуудын театр болгохоор шийдвэрлэсэн бөгөөд "Аглут" ХХК барилгын ажлыг гүйцэтгэсэн. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй тус Соёлын ордны барилга нь 850 хүний багтаамжтай бөгөөд барилгын гадна засварын 80 хувьтай явагдаж байна | |
| | 2.6.2.Улаанбаатар хотын музей болон Улаанбаатар хотын Нийтийн төв номын сангийн хүчин чадлыг нэмэгдүүлнэ | 3 | 2.6.2.1. Улаанбаатар хотын нийтийн төв номын сан болон салбар 4 номын сан, алслагдсан 3 дүүргийн Соёлын ордны номын санд фондын баяжилтыг жил бүр хийнэ. | 2021-2024 | НСУГ | Нийслэлийн төсөв | - | - | - | - | - | Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/130 дугаар захирамжаар Улаанбаатар хотын Нийтийн төв номын сан, салбар 4 номын сан, алслагдсан 3 дүүргийн соёлын ордны номын сангийн фондын баяжилтын тендерийн ажлыг зохион байгуулах эрхийг Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газарт шилжүүлсэн. "Улаанбаатар хотын нийтийн төв номын сангийн фондын баяжилт" хийх НХААГ/202212181 ажлын дугаартай тендерт шалгарсан "Мон судар паблишн" ХХК нь Нийслэлийн Засаг даргын тамгын газартай байгуулсан гэрээний дагуу ажлаа 100%-ийн гүйцэтгэлтэй хийж номын сан нь 335 нэр төрлийн 1605 ширхэг 48 351 675 төгрөгийн номыг хүлээн авч зохих журмын дагуу данс бүртгэлд бүртгэсэн. Улаанбаатар хотын нийтийн төв номын санд "Монсудар паблишн" ХХК-аас нийлүүлсэн дээрх номоос Улаанбаатар хотын алслагдсан Налайх, Багануур, Багахангай дүүргүүдийн соёлын ордны номын сангуудад тендерийн номын | 100% |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | жагсаалтад санал оруулснь дагуу нийт 278 нэр төрлийн 372 ширхэг 8.764.511 төгрөгийн номыг жагсаалтын дагуу хүлээлгэн өгсөн. Үүнд<br>• Налайх дүүргийн соёлын ордны номын санд 114 нэрийн 115 ширхэг 2.904.502 төгрөгийн ном<br>• Багануур дүүрэгт дүүргийн соёлын ордны номын санд 65 нэрийн 133 ширхэг 2.921.725 төгрөгийн ном<br>• Багахангай дүүргийн соёлын ордны номын санд 99 нэрийн 124 ширхэг 2.938.284 төгрөгийн ном Улаанбаатар хотын төв болон харьяа салбар номын сангуудад 130 нэр төрлийн 1233 ширхэг 39.587.170 төгрөгийн номыг хүлээн авч номын нэг бүрчлэн бүртгэн, нэгдсэн бүртгэлд бүртгэн техник ажиллагааг хийж 2022 оны 04-р улиралд багтаан уншлага үйлчилгээнд гаргасан. | |
| | 4. | 2.6.2.2. Улаанбаатар хотын нийтийн төв номын сан болон салбар 4 номын сан, алслагдсан 3 дүүргийн Соёлын ордны номын санд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх орчин нөхцөлийг бүрдүүлнэ. | 2021-2024 | НСУГ | Нийс-лэлийн төсөв | 736.0 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан тохижолттой номын сан байна | - | - | - | Д.Нацагдоржийн нэрэмжит Улаанбаатар хотын нийтийн төв номын сангийн хараагүй бэрхшээлтэй иргэдэд зориулсан уншлагын танхимын ном хэвлэлийн фондыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд хэвлэмэл номыг тусгай форматад хөрвүүлэх ажлыг Монгол Улсын Соёлын сайдын 2022 оны зардал баталж, эрх шилжүүлэх тухай А/179 дүгээр тушаал, Нийслэлийн Соёл, Урлагийн Газрын даргын 2022 оны А/36 дугаар тушаалын дагуу Д.Нацагдоржийн нэрэмжит Улаанбаатар хотын нийтийн төв номын сантай хамтран зохион байгуулав. Тус газраас төсөл санхүүжүүлэх гэрээг 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдөр Д.Нацагдоржийн нэрэмжит Улаанбаатар хотын нийтийн төв номын сантай байгуулсан ба гэрээний дагуу 23 ширхэг 6,999 хэвлэмэл хуудас бүхий 23 нэрийн | 100% |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | номыг хүртээмжтэй хэлбэрт хөрвүүлсэн ба төслийн хүрээнд дараах ажлуудыг гүйцэтгэв. Үүнд:<br>1. 23 нэрийн номыг хэвлэмэл байдлаар Улаанбаатар хотын нийтийн төв номын сангийн сан хөмрөгөөс авч, 6999 хуудсыг сканердаж, зурган файл болгосон.<br>2. Ном тус бүрээр бичвэр файл буюу word файл үүсгэсэн.<br>3. Ном тус бүрд орсон зургуудыг файлаар бэлтгэсэн.<br>4. Номыг хуудас бүрээр нь сканердахад гарсан үг үсгийн алдааг засварласан.<br>5. Үг үсгийн алдааг засварласан номыг редакторласан.<br>6. Номын бичвэр болон зургийг хүртээмжтэй хэлбэрт оруулж, редакторласан.<br>7. Номын зургуудыг тайлбарлан оруулсан.<br>8. Номыг олон улсын EPUB 3.0 хөрвүүлсэн.<br>9. Бэлэн болсон 23 нэрийн EPUB номыг харааны бэрхшээлтэй иргэд монгол хэлний ярьдаг программ, цахим брайл төхөөрөмж, цахим ном тоглуулагч зэрэг хэрэгслүүдийн аль нэгийг сонгож файл хэлбэрээр уншигдаж байна<br>Багануур дүүргийн соёлын ордоны номын санд "Ариун бичээс нийгэмлэг" ТББ-аас 48 ширхэг брайл ном хандивласан. | |
| 5. | 2.6.2.3. Улаанбаатар хотын музейн барилгыг засварлаж үйл ажиллагаагаар боловсрол түүх соёлын танин мэдэхүйн чиглэлээр | 2021-2024 | НСУГ | Нийслэлийн төсөв | 6.800.0 | Барилгы төсөв хийж дууссан. | - | - | - | Музейн барилгыг түүхэн байгууламж хэлбэрээр сэргээн засварлах, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах, өргөтгөлийн шинэ барилга барих саналыг удирдах дээд байгууллагад хүргүүлж, шийдвэрлүүлэх ажлын хүрээнд тендерт шаардлагатай техникийн тодорхойлолтыг боловсруулж өгсөн. Дээрх ажлын хүрээнд Нийслэлийн худалдан авах | 100% |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | ажиллагааны газарт 202202289 дугаартай тендер зарлагдаж “Онь тэнгэрийн бичиг” ХХК шалгарч засварын ажил хийгдэж дууссан.<br>Тус компаниас камер, дохиоллын системийн тоног төхөөрөмж-32,095,580, цахилгаан болон барилгын урсгал засвар-67.110.360, шаардлагатай тоног төхөөрөмжийн зардал -120.153.400 нийт 219,359,660 төгрөгийн өртөг бүхий тоног төхөөрөмжийг нийлүүлсэн.<br>- НЗДТГ-ын ХБТХ-ээс явуулсан бичгийн дагуу Нийслэлийн 2023 оны төлөвлөгөөний төсөлд “Шинээр хэрэгжүүлэх барилга байгууламж”-ийн санал, төсөл, арга хэмжээ холбогдох мэдээллийг https://pimis.publicinvestment.gov.mn/ цахим системд оруулан хавсралт маягтын дагуу боловсруулан албан бичиг болон цахим хэлбэрээр НЗДТГ-ын ХБТХ-д илгээж ажилласан. | |
| | 2.6.3.Хотын соёлыг төлөвшүүлж түгээн дэлгэрүүлэх ажлыг бүх шатанд зохион байгуулна. | 6. | 2.6.3.1."Хотын соёл" цуврал контент бий болгож цахим аян хэрэгжүүлнэ. | 2021-2024 | НСУГ | Нийслэл төсөв | 1,040,0 | “Хотын соёл олон нийтийн; хүрээнд цуврал 7 конгтент | Цуврал контентийг 10-аар нэмэгдүүлсэн байна. | 358,16<br>5,5 | 261,16<br>4,5 | 1.“Хотын соёл-2022” цахим нөлөөллийн аяныг нийслэлийн хэмжээнд хэрэгжүүлэх Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/676 дугаартай захирамж гарсан ба захирамжийн дагуу “Хос Анааш” ХХК, “Анури энтертейнмент” ХХК, “Эс би продакшн” ХХК-уудтай ажил гүйцэтгэх гэрээ байгуулан “Хотын соёлтой иргэн” сэдэвт хотын соёлд уриалах нөлөөллийн цуврал нэвтрүүлгүүд, “Урбан номад медиа” ХХК-тай гэрээ байгуулан цуврал подкастууд, “Эм Жи Эл радио ньюс” ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулан “Дөрвөн зүгийн шуугиан”, “Улаан малгайт”, “Элдэв шипи”, “Үдийн хачир”, “Радио зөвлөгөө”, “Нэг дусал” зэрэг радио нэвтрүүлгүүдээр дамжуулан иргэдэд хамтдаа амьдрах соёл, | 95% |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | ахуйн соёл. Монголчуудын эрхэмлэн дээдлэх 9 үнэт зүйлийг таниулан сурталчлах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Мөн "Тэнгэр медиа пи ар групп" ХХК, "Үнэний ташуур" НҮТББ, "Гурав арван нэг сэтгүүлчдийн клуб" ТББ, "Хурц харандаа" хэвлэл мэдээллийн байгууллагуудтай тус тус хамтран олон нийтэд Хотын соёл нөлөөллийн аяныг цахимаар сурталчилсан.<br>2. Нийслэл хотоос соёлын талаар баримталж буй бодлогыг иргэд, олон нийтэд сурталчилж, иргэдийн нийтийн соёлыг дээшлүүлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг бүх нийтийн хэрэг болгох зорилгоор соёлын үйл ажиллагаа хүрч чадахгүй байгаа төвийн 6 дүүргийн гэр хорооллын 36 хороодод хүрч ажиллах мөн нийслэлд сургалтын үйл ажиллагаа эрхэлж буй 65 их сургуулийн нэгдүгээр курсын оюутнуудад чиглэн нийтийн соёлыг дээшлүүлэх зорилгоор Хотын соёл-Хариуцлагатай иргэн аяныг 2022.08.29-2022.09.10-ны өдрүүдэд 2 төрлийн арга хэмжээг Цагдаагийн ерөнхий газрын урьдчилан сэргийлэх хэлтэс, Сүү ХК-тай хамтран зохион байгуулж нийт 20862 оюутан, 7 мянга гаруй иргэдэд хүрч ажиллалаа. Аяны тухай мэдээ мэдээллийг Нийслэлийн Соёл, урлагийн газрын цахим хуудас, төвийн 6 дүүрэг, 36 хороодын цахим хуудас мэдээллийн самбараар түгээсэн бөгөөд ETV, TV5 телевизүүдээр цаг үеийн мэдээллийг дамжуулсан. | |
| 2.6.4 Урлагийн олон төрөл зүйлийг жигд хөгжүүлж, иргэд, олон нийт болон гадаадын жуулчдад сурталчлан | 7. | 2.6.4.1. Үндэсний агуулга шингэсэн Уран бүтээлийг дэмжинэ. | 2021-2024 | НСУГ | Нийслэлийн төсөв | 1 000.0 | Үндэсний агуулга шингэсэн 1 уран бүтээл байна | Жилд 1 уран бүтээлийг дэмжинэ. | 250.000 | 109.1000 | "Үндэсний урлагийн сар"-ын хүрээнд:<br>- Нийслэлийн Засаг даргын 2022 оны А.1019 дүгээр захирамжийн хүрээнд "Даншиг наадам-Хүрээ цам" наадмыг 2022 оны 08 дугаар сарын 06-ний өдөр Хүй долоон | 100 |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | таниулах ажлыг эрчимжүүлж, үндэсний агуулга шингэсэн бүтээлийн тоог нэмэгдүүлнэ. | | | | | | | | | | | худагт зохион байгуулагдсан. Наадмыг 6000 орчим иргэд, жуулчид ирж үзсэн. Нийслэлийн Соёл, урлагийн газрын А/43 дугаар тушаалын дагуу дээрхи үйл ажиллагаанд 37,000,000 сая төгрөгийн төсвийг зарцуулсан.<br>- Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 11/34 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1153 захирамжийн хүрээнд 2022 оны 07 дугаар сарын 12-с 08 дугаар сарын 01-ний хооронд 9 дүүргийн Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдын дунд шалгаруулалт зохион байгуулан шилдэг 56 оролцогчийг шалгаруулан, 2022 оны 08 дугаар сарын 12-14-ний өдрүүдэд Горхи тэрэлж цогцолборт "Нүүдэлчин" дэлхийн соёлын фестивальд Нийслэлийн отог байгуулан оролцсон бөгөөд Нийт 4 төрөлд шилдэгээр шалгарсан. Тус наадамд 9 дүүргийн 25900 гаруй иргэдэд хүрч үйлчилсэн. Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1153 захирамжийн дагуу 87,245,000 сая төгрөгийг зарцуулсан.<br>- Нийслэлийн засаг даргын 2022 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн А/676 дугаар захирамжийн дагуу "Хотын соёл-2022" цахим нөлөөлийн аяны хүрээнд Нүүдэлчдийн давлагаа НҮТББ-тэй хамтран "Үндэсний хөгжим өв соёлыг орчин цагийн хөгжимтэй шинэчлэн найруулсан Synth Symphony Dj&Orchestra тоглолтыг 2022 оны 11-р сарын 11-ний өдөр MPM event hall-д Монголын улсын филармони, DJ нарын холбоо хамтарсан амьд хөгжмийн тоглолтыг зохион байгуулсан. Тус арга хэмжээний идэвхжүүлэлт сошиал хаягууд, Боловсрол ТВ сувгуудаар цацсан | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | сурталчилгаануудын үр дүн нь нийтдээ давхардсан тоогоор 2 сая хүртэлх хандалт аван тухайн өдрийн арга хэмжээнд 750 хүн хүрэлцэн ирсэн. Уг арга хэмжээнд Нийслэлийн засаг даргын 2022 оны 05 дугаар сарын 20-ний өдрийн А/676 дугаар захирамжийн дагуу "Хотын соёл-2022" цахим нөлөөллийн аяны хүрээнд 5.000.000 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. | |
| | | 8. | 2.6.4.2."Улаанбаатар" олон улсын кино наадам, Сонгодог урлагийн гала фестивалийг жил бүр зохион байгуулна. | 2021-2024 | НСУГ | Нийс-Лэлийн төсөв | 1,000. 0 | Кино наадам, Сонгод ог урлагийн гала тоглол тыг тус тус зохион байгуулсан | Жил бүр кино наадам сонгодог урлагийн гала фестивалийг тус тус зохион байгуулна. | 250,00 0,0 | 92.268, 0 | -"Сонгодог урлагийн сар"-ын хүрээнд Гэгээн муза театрын урлагийн наадмыг 5, 6-р сард зохион байгууллаа. Наадамд оролцсон шилдэг жүжгүүдийг 2022 оны 05 дугаар сарын 28-наас 06 дугаар сарын 10-ны өдрүүдэд Улсын Драмын Эрдмийн Театр, Улсын Дуурь бүжгийн Эрдмийн Театр, Нийслэлийн Соёлын төв өргөө, Монголын Үйлдвэрчний эвлэлийн Соёлын төв ордон, Монголын Хүүхдийн Ордон, Монгол Улсын Хүүхэлдэйн Театрын тайзнаа иргэд жуулчдад зориулан тоглуулж нийт 15 жүжгийг 6,000 гаруй хүн үзэж сонирхсон.<br><br>- Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1206 дугаар захирамжийн хүрээнд 2022 оны 09 дүгээр сарын 24-ны Автомашингүй өдөр 2022"-ийн хүрээнд Улсын Дуурь Бүжгийн Эрдмийн театрын 11 уран бүтээлчид Сонгодог урлагийн сарын хүрээнд түүвэр тоглолтыг 10000 орчим иргэнд Д.Сүхбаатарын талбайд толилуулсан. Тус өдрийг 19.300.000 сая төгрөгийн төсвийг зарцуулсан.<br><br>- Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1406 захирамжийн хүрээнд "Улаанбаатар" олон улсын XIV удаагийн кино наадмын зохион | 100% |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | байгууллалтад дэмжлэг үзүүлсэн бөгөөд нийт 19 орны 50 гаруй бүтээл өрсөлдсөн. "Хангарьд" монгол киноны уралдаанд 8 кино өрсөлдөж "Шилдэг кино" төрөлд Этгээд, "Шилдэг найруулагч"-аар Б.Баатар Этгээд УСК. "Шилдэг зохиолч"-оор Э.Ган-Эрдэнэ, Н.Майдар. Дасгалжуулагч УСК. "Шилдэг продюсер"-оор В.Ганзориг, Г.Булгантамир. "Трио" УСК зэргийг шалгаруулж шагналыг гардуулсан. Уг наадам нь 2022 оны 10 дугаар сарын 17-23-ны өдрүүдэд Тэнгис кино театрт давхардсан тоогоор 1200 кино сонирхогчид хүрсэн. Тус наадмыг 32,176,250 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэн хамтран зохион байгуулсан. | |
| | 9. | 2.6.4.3. Иргэд, жуулчдад зориулсан нийтийг хамарсан урлагийн тоглолт, үйл ажиллагаа зохион байгуулна. | 2021-2024 | НСУГ | Нийслэлийн төсөв | 6.174.0 | Нийтийг хамарсан урлагийг ажиллагыг зохион байгуулс | 10 урлагийн тоглолт зохион байгуулсан байна | 1.174.0 | - | Иргэд, жуулчдад зориулсан 4 удаагийн тоглолтыг зохион байгуулж, 6 тоглолтыг хамтран зохион байгуулж ажилласан. Үүнд:<br>-Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээг 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдөр Жанжин Д.Сүхбаатарын талбайд "Энх Тунх-Мөнх Тунх" уриатайгаар зохион байгуулсан бөгөөд 30,000 хүн хамрагдсан<br><br>-Тулгар төрийн 2230, Их Монгол Улсын 815, Ардын хувьсгалын 100, 101 жилийн ойг тохиолдуулан "Улаанбаатарын үдэш" тоглолтыг 2022 оны 07 дугаар сарын 13-15-ны өдрүүдэд Хүй 7-н худагт зохион байгуулсан бөгөөд 15,000 хүн үзэж сонирхсон.<br><br>-Төв цэнгэлдэх хүрээлэнд "Ice top-Миний Нийслэл", "Зуны зугаа", "Triple X", "Камертон-27 жил", "XMF" Олон улсын нэрт реппер Lil Pump Люмино, Татар хамтлагийн "The Best" тоглолтуудыг хамтран зохион байгуулсан. | 100% |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | - Нийслэлийн засаг даргын 2022 оны 05 дугаар сарын 20-ний өдрийн А/676 дугаар захирамжийн хавсралтаар батлагдсан "Хотын соёл-2022" цахим нөлөөлийн аяны хүрээнд Хүүхэд залуусыг соён гэгээрүүлэх үйлсэд хувь нэмрээ оруулах зорилгоор Тоонот рекордсын 21x21 төслийн хүрээнд "Нэгдүгээрт хүүхэд", "Аажуу явбал аяндаа хүрнэ дээ" зэрэг улсын хэмжээнд хэрэгжиж буй томоохон арга хэмжээнүүдийг сурталчилж мөн аялан тоглолтынхоо хаалтыг төв талбайд 2022 оны 09- дүгээр сарын 09-ны өдөр Д.Сүхбаатарын талбай дээр зохион байгуулсан. Тоглолтыг 100.000 гаруй хүүхэд залуучууд үзсэн.<br><br>- Нийслэлийн 383 жилийн ойн хүрээнд Д.Лувсаншаравын нэрэмжит "Хүүхдийн Найрал дууны наадам" XXVIII удаагийн уралдааныг 2022 оны 10 дугаар сарын 12-26-ний хооронд 9 дүүргийн хэмжээннд Хоёр үе шаттай зохион байгуулсан. Наадмын эхний шатанд есөн дүүргийн 82 сургуулийн 5000 орчим сурагч оролцон. хоёрдугаар шатанд 20 сургуулийн найрал дууны хамтлаг буюу 2200 орчим сурагчид шалгарсан. 2022 оны 10 дугаар сарын 26-ний өдрийн Гала тоглолтыг Соёлын төв өргөөнд зохион байгуулж ерөнхий боловсролын 1200 сурагчид буюу 15 сургуулийн хамтлаг оролцсон. Наадмыг Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1408 дугаар захирамжийн дагуу 114.850.000 сая төгрөгийн төсөвтэйгээр зохисн байгуулсан. | |
| 2.6.5.Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг оюуны өмч | 10 | 2.6.5.1 Улаанбаатар хотын Соёлын бүтээлч | 2021-2024 | НСУГ | Нийслэлийн төсөв | 190.0 | - | - | - | - | Нийслэлийн Засаг даргын 2022 оны 05 сарын 18-ны өдрийн А/659 дугаар захирамжаар "Дамбадаржайлин хийдийн | 80% |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | зохиогчийн эрх, инновацид тулгуурлан хөгжүүлнэ^ | | үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих инкубатор төв байгуулна. | | | | | | | | | Цогчин дуганд хийж гүйцэтгэсэн их засвар, хөрөнгө оруулалт, түүх соёлын үл хөдлөх газрын хамгаалалтын бүс, өмчлөлийн асуудлыг судалж, цаашид авах арга хэмжээний талаар санал боловсруулах ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хэсэг газар дээр очиж нөхцөл байдалтай танилцсан бөгөөд дараах саналыг НИТХ-д оруулахаар бэлтгэж байна.<br>-Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанаас 2023 оны төлөвлөгөөнд Дамбадаржаалин хийдийн газрыг 45164м кв талбайгаар тусган Нийслэлийн өмчид бүртгүүлэх<br>-Одоо байгаа газрын кадастрын мэдээллийн санд бүртгэгдсэн 2830м.кв талбайд газрын төлбөрийн ногдуулалт хийхэд 1.426.252 төгрөгний төлбөр төлөх үлдэгдэлтэй байна. Уг төлбөрийг төлүүлэх.<br>-Нийслэлийн хот байгуулалт хөгжлийн газраас хийд орчим олон нийт, аялал жуулчлалын бүс болгох<br>-Монголын бурхан шашинтны шинэ төвийн тэргүүн З.Санждоржийн зүгээс Цогчин дуганы засварын ажилд зарцуулсан 440,121,622 сая төгрөгийн улсаас гаргуулах | |
| | 2.6.6. Нийслэлийн харьяа соёл, урлагийн байгууллагуудын удирдлага, зохион байгуулалтын тогтолцоог боловсронгуй болгож, иргэдэд үйлчлэх соёлын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ. | 11 | 2.6.6.1. "Улаанбаатар" чуулгын үйл ажиллагааг өргөжүүлж, театрын статустай болгоно. | 2021-2024 | НСУГ | - | - | - | Театрын статуста й болгосон байна. | - | - | Улаанбаатар чуулгын үйл ажиллагааг өргөжүүлж, театрын статустай болгох асуудлыг Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж "Улаанбаатар театр" нэртэй болж, 11 дүгээр сарын 08-ны өдрийн 148 дугаар тогтоолоор Улаанбаатар театр орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газар болгон өөрчилж, дүрмийг хавсралтаар баталсан. | 100% |

Нийслэлийн худалдан авах ажиллагааны газраас зарласан НХААГ/202202288 дугаартай Тендерийн сонгон шалгаруулалтад "Винтер Гарден" ХХК шалгарсан бөгөөд 50 сая төгрөгний тайзны тоног төхөөрөмжийн шинэчлэлт хийгдсэн

Соёлын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор алслагдсан 3 дүүрэг болох Багануур, Багахангай, Налайх, дүүрэгт соёлын ордон барих ажил хэрэгжиж байна.

Нийслэлийн хөрөнгө оруулалтаар багануур дүүрэгт баригдаж буй 850 хүний суудалтай барилга нь 2017 онд эхэлж, 15,7 тэрбум төгрөг тусгаснаас хөрөнгө оруулалтаас шалтгаалж зогсонги байсан ба 2022 онд 3 тэрбум төгрөгийн санхүүжилт хийгдэж, "Эн Ар" ХХК гүйцэтгэж байна. Тус барилга нь одоогийн байдлаар барилгын суурь, зоорийн давхар баригдсан. Барилгын явц 40%-тай байна. Нийт 7,3 тэрбумын санхүүжилт хийгдсэн.

-Нийслэлийн хөрөнгө оруулалтаар Багахангай дүүрэгт баригдаж буй 500 хүний суудалтай соёлын ордны шинэ барилгын ажлыг "Адамант ХХК" барьж буй Соёлын ордны барилгын ажлын гүйцэтгэл 10 хувьтай. 2022 онд нийт 20 хүнтэй 3 бригад ажиллуулсан Цахилгааны 5 хүнтэй 1 бригад, арматурын 6, цутгалт, хучилтын болон туслах ажлын 9 хүнийг ажиллуулсан. Зоорин давхрын арматурын ажил бүрэн дуусч, цахилгаан холболтын монтажуудыг байршуулан, ногоон өнгийн бүтээлгээр цас, хүйтнээс хамгаалан битүүлэн төхөөрөмжилсөн. 80 орчим тн цемент, 6 машин хайрга, 6 машин

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | дайрга татан хучилт хийхээр ажиллаж байх хугацаанд Нийслэлийн хөрөнгө оруулалтын газраас Цаг агаарын хувьд хүйтэрсэн учир цутгалт хийгдэх боломжгүй гээд 11 дүгээр сарын 09-ний өдрөөс ажлыг нь зогсоосон. | |
| | 2.6.7.Улс, нийслэл, Дүүргийн хамгаалалтад байх түүх соёлын дурсгалт газар, барилга байгууламжийг бүсчлэн хувааж аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгоно. | 12. | 2.6.7.1.Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг танилцуулах, сурталчлах аппликэйшн бүтээж, соёлын аялал жуулчлалын эргэлтэд оруулах ажлыг үе шаттай зохион байгуулна. | 2021-2024 | НСУГ | Нийс-лэлийн төсөв | 118,0 | | Аппликэйшн бүтээсэн байна. | 66,000 | 66,000 | Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/581 дүгээр захирамж, Нийслэлийн Соёл, урлагийн газрын даргын 2021 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн А/26 дугаар тушаалын дагуу “Чингис системс” ХХК-ний хэрэгжүүлж буй “Mongol Events” төслийн хүрээнд Нийслэлийн нутаг дэвсгэрт байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалуудыг QR кодоор танилцуулах аппликэйшн бүтээсэн. Аппликэйшнд нийслэлийн нутаг дэвсгэрт байх улсын хамгаалалтын зэрэглэлтэй түүх, соёлын үл хөдлөх дурсгал болох Засгийн газрын 2020 оны 13 дугаар тогтоолоор батлагдсан 15 дурсгал, Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын сайдын 2020 оны А/161 дүгээр тушаалаар батлагдсан 14 дурсгал, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2021 оны 12/35 дугаар тогтоолоор батлагдсан 144 дурсгал, Соёлын өвийн Үндэсний төвийн RICH программд бүртгэлтэй, нийт 217 дэсийн 479 дурсгалын мэдээллийг оруулан, хөгжүүлэлт хийсэн бөгөөд олон улсад нэвтрэх зөвшөөрөл түр хүлээгдэж байна. | 80% |

ТАНИЛЦСАН:
НИЙСЛЭЛИЙН СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН ДАРГА О.АНХБАЯР

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА М.БАДРАХ

НЭГТГЭСЭН:
МЭРГЭЖИЛТЭН Б.Ундрах. Б.УНДРАХ